



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/23

Номгон

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх
үндэсний хөтөлбөр”-ийг 2021 онд хэрэгжүүлэх
арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 102 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал 3.0 сая төгрөгийг Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс /С.Байгалмаа/-д зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс /Д.Сарангарав/-т үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /М.Өнөржаргал/-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХСАЙХАН

1 10061